ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар 07/01 Сайншанд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сэврэй сумыг 2023-2032 онд хөгжүүлэх сумын хөгжлийн дунд хугацааны бодлого төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны үнэлгээг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Огтбиш (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)

Гишүүд: Б.Цэнгэл (Ёс зүйн хорооны дарга)
А.Алтанцэцэг (Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны дарга)
Ө.Аюуш (Эдийн засаг, өмч, төсөв санхүү, дэд бүтцийн хөгжлийн хорооны дарга)
Д.Мөнхжин (Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга)
Б.Одгэрэл (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)
Д.Бямбадэлгэр (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)
С.Мөнхсайхан (Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Н.Долгор (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
Ц.Дашбат (Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Ш.Одмаа (Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга)

2. Сумын хөгжлийн дунд хугацааны бодлого төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны үнэлгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хийж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Огтбиш)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ